



МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ

Нэгдсэн үндэстний гудамж 5,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-15-53, Факс: 32-88-34,
Цахим шуудан: info@mlsp.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2025.07.07 № 02/2315

танай _____-ны № _____-г

МОНГОЛЫН ТЭЭВЭР, ХОЛБОО,
ГАЗРЫН ТОСНЫ АЖИЛТНЫ ҮЭ-ҮҮДИЙН
ХОЛБООНЫ ДАРГА М.БОЛДСАЙХАН ТАНАА

Иргэний нисэхийн салбарт 2025-2027 онд
хэрэгжих хамтын хэлэлцээртэй танилцлаа.

Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар
зүйлийн 32.2 дахь хэсэгт заасны дагуу Иргэний
нисэхийн салбарт 2025-2027 онд хэрэгжих хамтын
хэлэлцээрийг 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдөр
бүртгэсэн болно.

Хэлэлцээрийн хувиудыг хавсаргав.



Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
Удирдлага
Төрийн нарийн бичгийн дарга
Л.Мөнхзул
2025.07.07 16:24

БҮРТГЭВ.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

2025 оны 07 сарын 04 ны өдөр

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАРТ 2025-2027 ОНД
ХЭРЭГЖИХ ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Хэлэлцээрт оролцогч талууд:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
ТӨВ БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

Зам, тээврийн яам

АЖИЛ ОЛГОГЧДЫГ ТӨЛӨӨЛЖ:

Иргэний нисэхийн ерөнхий газар

“Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК

“МИАТ” ТӨХХК

АЖИЛТНЫГ ТӨЛӨӨЛЖ:

Монголын тээвэр, холбоо, газрын
тосны ажилтны үйлдвэрчний
эвлэлүүдийн холбоо

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 34, 35, 36 дугаар зүйлийг тус тус үндэслэн Иргэний нисэхийн салбарын хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын нийтлэг эрхийн хэм хэмжээг тогтоож боловсронгуй болгох, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, үйл ажиллагааны харилцан үр ашигтай байдлыг хангах, хөдөлмөрийн хууль тогтоомжуудад тусгагдаагүй нарийвчилсан харилцааг зохицуулах, суурь хэм хэмжээнүүдийг дээшлүүлэх зорилгоор оролцогч талууд хэлэлцээ хийж, харилцан тохирч энэхүү хамтын хэлэлцээрийг байгуулав.

1.2. Хамтын хэлэлцээр нь талууд гарын үсэг зурж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болж мөрдөгдөх бөгөөд 2 жилийн хугацаанд хэрэгжүүлж, дуусахад талууд шинээр хэлэлцээр байгуулах эсэх талаар санал гаргаагүй бол дараагийн хэлэлцээр байгуулагдах хүртэлх хугацаанд энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

У.Монхуур

Зам

1

Хөдөлмөр, нийгмийн
хамгааллын яам хамтын
хэлэлцээрийг бүртгэв

1.3. Талууд харилцан тохиролцсоноор хамтын хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд хэлэлцээрийн талуудад ажлын 15 хоногийн өмнө бичгээр мэдэгдэж шийдвэрлэнэ.

1.4. Иргэний нисэхийн салбарын төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшлийн өмчийн харьяалал, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөх тохиолдолд хамтын хэлэлцээр хүчин төгөлдөр байх бөгөөд энэ хэлэлцээрийн заалтуудаас илүү нөхцөлөөр тохиролцсон Хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээний заалтууд хэвээр мөрдөгдөнө.

1.5. Хэлэлцээрийн биелэлтэд талуудын төлөөлөгчид, мөн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

1.6. Талууд хамтран буюу дангаар уг хэлэлцээрийн биелэлтийн явц байдлыг жил тутамд гаргаж, хамтарсан хурлаар хэлэлцэж, мэдээллийг иргэний нисэхийн салбарын аж ахуйн нэгж, байгууллага, түүний нийт ажилтан, хамт олонд хүргэж танилцуулсан байна.

1.7. Талууд Хамтын хэлэлцээрийн нөхцөл, биелэгдээгүй зүйл, заалтын талаар шаардлага гаргах, саналын зөрүүтэй асуудал үүссэн тохиолдолд хөдөлмөрийн сонирхлын маргаан үүсгэж болно.

1.8. Хамтын хэлэлцээрийн явцад үүссэн хөдөлмөрийн сонирхлын маргааныг талууд боломжит бүхий л арга хэмжээг аван харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд хэрэв үр дүн гараагүй бол хөдөлмөрийн зуучлагчийн дэмжлэгтэйгээр маргааныг зохицуулах, эсхүл хөдөлмөрийн арбитраар маргааныг шийдвэрлүүлнэ.

1.9. Хамтын хэлэлцээр нь өмнөх хүрсэн түвшнийг бууруулалгүй, тасралтгүй сайжруулах зарчим баримтална.

1.10. Хамтын хэлэлцээр нь тухайн салбарын нийт ажил олгогч болон ажилтныг хамаарч үйлчилнэ.

Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийн талаар


2.1. Ажил олгогч нь аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, нэгж татан буугдсаны улмаас ажилтнуудыг цомхотгох, бөөнөөр халах, ажлын байрыг олноор цөөрүүлэх, хөдөлмөрлөх нөхцөлийг дордуулахад хүргэх орон тоо, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг хийхдээ 30 хоногийн өмнө холбогдох үйлдвэрчний эвлэлийн байгууллагад урьдчилан мэдэгдэж, ажилтны хууль ёсны ашиг сонирхлыг хангах, нийгмийн хамгааллын талаар гэрээ байгуулж, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бичгээр мэдэгдэнэ.

2.2. Салбарын нийт аж ахуйн нэгж, байгууллага нь ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулах ба ажилтан ажил үүргээ гүйцэтгэж эхэлснээр хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүснэ. Ингэхдээ ажилтанд урьдчилан албан тушаалын тодорхойлолтыг танилцуулсан байна.

2.3. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх хүртэл 24 сарын хугацаа дутуу байгаа ажилтнуудыг цомхотголд оруулахгүй, менежментийн гэрээгээр шилжүүлэхгүй бөгөөд хэрэв тухайн ажлын байр нь хасагдсан тохиолдолд цалин

У. Манхуур

Эмг 2



хөлс, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг дордуулахгүйгээр өөр ажилд шилжүүлж ажлын байраар хангана.

2.4. Байгууллагын түвшинд тухайн жилийн цалин хөлс, нийгмийн хамгаалалтай холбогдсон төсвийн төсөл боловсруулах, зарцуулах асуудлаар Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын саналыг харгалзаж үзнэ.

2.5. Салбарын ажиллагсдын хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэхтэй холбоотой хөтөлбөр, төслийг боловсруулж хэрэгжүүлэхдээ тухайн ажил олгогчдын болон үйлдвэрчний эвлэлийн байгууллагын оролцоог хангаж ажиллана.

Гурав. Цалин хөлсний талаар

3.1. Засгийн газраас цалин хөлсийг нэмэгдүүлсэн, хэрэглээний үнэ тариф, ажлын ачаалал нэмэгдсэн үед төрийн өмчит болон хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллагууд тухайн жилийн бизнес төлөвлөгөө, зорилтот түвшинтэй уялдуулан ажилтны гүйцэтгэсэн ажлын нэгжид ногдох цалингийн үнэлгээг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

3.2. Салбарын ажиллагсдын цалин хөлсийг хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулж, урт хугацаанд олон улсын жишигт нийцүүлэх чиглэл баримтлах бөгөөд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос тогтоосон хэмжээнээс 1.8 дахин их байна.

3.3. Ээлжийн хуваарийн дагуу нийтээр амрах баярын өдрүүдэд ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй тохиолдолд нэмэгдэл хөлсийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан хувь хэмжээ, түүнээс дээш хэмжээгээр Хамтын гэрээ, дотоод хэм хэмжээнд заасны дагуу олгоно.

3.4. Талууд Иргэний нисэхийн салбарын ажиллагсдын цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгох, тооцоо судалгааг үндэслэн нийтлэг ажил мэргэжлүүдийн тариф, цалинг тогтоох талаар хамтран ажиллана.

3.5. Аж ахуй нэгж байгууллага болон түүний салбар нэгж татан буугдсан, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр орон тоо нь хасагдсан, бөөнөөр халах, өөр ажилд шилжсэн ажилтанд цалин, хөлс, тэтгэмжийг иргэний нисэхийн салбарт ажилласан жилийг нь харгалзан Хамтын гэрээнд заасны дагуу олгоно.

3.6. Иргэний нисэхийн салбарт ажиллаж байгаад тэтгэвэрт гарах ажилтанд иргэний нисэхийн салбарт ажилласан жилийг харгалзан 3-36 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно. Хамтын гэрээ, дотоод хэм хэмжээгээр зохицуулна.


3.7. Ажилтныг удаан жил, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор иргэний нисэхийн салбарт ажилласан жилийн нэмэгдлийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр олгоно. Хамтын гэрээ, дотоод хэм хэмжээгээр зохицуулна.

3.8. Байгууллагын жилийн эцсийн үр дүнг үндэслэн нийт ажилтнуудад шагналт цалинг олгоно. Хамтын гэрээ, дотоод хэм хэмжээгээр зохицуулна.

3.9. Ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагыг үндэслэн ажилтанд мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 10 болон түүнээс дээш хувиар тооцож ажлын

У. Манжжар

3



байрны жагсаалт гаргаж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу олгоно. Хамтын гэрээ, дотоод хэм хэмжээгээр зохицуулна.

3.10. Амаржсаны болон ээлжийн амралтаа эдэлсэн эхэд өөрийн хүсэлтийг нь үндэслэн хүүхдийг нь гурван нас хүртэл тухайн байгууллагын Хамтын гэрээгээр тохиролцсоноор чөлөөтэй байх хугацааны тэтгэмжийг олгож, нийгмийн даатгалын шимтгэлийг төлнө. Энэ хөнгөлөлт, тэтгэмж нь нярай хүүхэдтэй ганц бие эцэг, нярай үрчлэн авсан эцэг, эхэд нэгэн адил хамаарна.

3.11. Агаарын тээврийн хүртээмжийг дээшлүүлэх, нислэгийн аюулгүй байдлыг тасралтгүй хангах зорилгоор орон нутгийн салбар, нэгжүүдэд ажиллаж буй ажилтнуудад орон нутгийн нэмэгдлийг Хамтын гэрээ, дотоод хэм хэмжээнд заасан хэмжээгээр сар бүр олгоно.

Дөрөв. Хөдөлмөр зохион байгуулалт, хөдөлмөрийн норм нормативын талаар

4.1. Ажил амралтын цагийн горимыг байгууллагын ажлын онцлогтой уялдуулж зохицуулан баталж мөрдүүлнэ.

4.2. Ажилтны ажлын өдрийн үргэлжлэх хугацаа 8 цаг, долоо хоногийн ажлын өдрийн ажиллах нийт хугацаа 40 цагаас хэтрэхгүй байна.

4.3. Ээлжээр ажилладаг ажилтны шөнө ажилласан нэг цагийн нэмэгдэл хөлсийг олгохдоо түүний дундаж цалин хөлсийг 1,3 дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж Хамтын гэрээ, дотоод хэм хэмжээнд заасны дагуу олгоно.

4.4. Ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтны нэмэгдлийг үндсэн цалингийн 10 ба түүнээс дээш хувиар олгож, хүйтний нэмэгдлийг Хамтын гэрээгээр шийдвэрлэн олгоно.

4.5. Ажилтанд эрхлэн гүйцэтгэдэг ажлын онцлогийг харгалзан ажлын тусгай хувцас, бие хамгаалах хэрэгсэл, хор саармагжуулах бүтээгдэхүүн, ариутгах, цэвэрлэх, угаах бодисоор үнэгүй хангахын хамт хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны жагсаалт, норм, техникийн шаардлагыг баталж мөрдүүлнэ.


4.6. Ажилтны мэргэжлийг дээшлүүлэх мэргэшүүлэх, шинэ мэргэжил эзэмшүүлэх болон өмч хувьчлах, өөрчлөн байгуулах үед ажлын байрны баталгааг хангана.

4.7. Иргэний нисэхийн салбарын нарийн мэргэжлийн ажилтнуудын ажлын байрны баталгааг хангах зорилгоор тухайн ажлын байранд дотоодын ажиллах хүч байгаа тохиолдолд гадаад улс орны ажиллагсдыг авч ажиллуулахгүй байх бодлогыг баримтална.

4.8. Ажилтнаас хамаарахгүй шалтгаанаар сул зогсолт гарвал ажилтанд сул зогсолтын нөхөн олговрыг үндсэн цалингийн 70 хувь, түүнээс доошгүй хувь хэмжээгээр олгоно.

У. Мөнхүүрэн

4



Тав. Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, стандарт хангах талаар

5.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийг жил бүр индексжүүлэн хуулийн дагуу нэг удаа олгоно.

5.2. Ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ажлын байрны эрүүл ахуйн шаардлагыг хангах үүднээс жил бүр байгууллагын зардлаар хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, ажлын байрны нөхцөлийн үнэлгээг тоног төхөөрөмж нэмэгдэх болон ажлын байрны орчны нөхцөл өөрчлөгдөх тухай бүрд нь байгууллагын зардлаар хийлгэнэ.

5.3. Мэргэжлийн байгууллагуудаас хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн үнэлгээ, дүгнэлт гарсан ажлын байруудад ажиллагсдыг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн хөнгөлөлт болон ажлын цагийг Хамтын гэрээ, дотоод хэмжээнд заасны дагуу зохицуулна.

5.4. Эрсдэлтэй ажлын байрны жагсаалтын дагуу ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулна.

5.5. Талууд Үндэсний ажил мэргэжил, албан тушаалын жагсаалт, ангилал, тодорхойлолтод тусгагдсан ажлын байрны нэршил, үндэсний кодыг хэрэглэж хэвшүүлэх чиглэлээр хяналт тавьж, ижил чиг үүрэг гүйцэтгэж буй ажлын байруудын YAMAT-08 кодыг дүйцүүлэн хэрэглэх ба жагсаалтад ороогүй ажил мэргэжлийг оруулахаар хамтран ажиллана.

5.6. Мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан ажлын байрны нэршлийг Тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалтад хамруулахаар талууд хамтран ажиллана.

5.7. Ажил олгогч нь үйлдвэрлэлийн явцад бий болсон хими, физик, биологийн хүчин зүйл нь ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, техник, зохион байгуулалтын арга хэмжээ авах зардлыг хуульд заасны дагуу төсөвлөж, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулна.

5.8. Үндсэн ажилтнууд болон үндсэн ажлын байранд түр ажиллаж буй ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зардлыг ажил олгогч хариуцна.

Зургаа. Ажилтнуудын мэргэжил боловсролын талаар


6.1 Ажил үйлчилгээний шаардлагыг харгалзан байгууллагын хөрөнгөөр дотоод болон гадаадын байгууллагуудад мэргэжлийн дээд боловсрол олгох, мэргэжил дээшлүүлэх, давтан сургах ажлыг жил бүр төлөвлөгөөний дагуу явуулна.

6.2 Ажилтан хувиараа суралцах тохиолдолд ажилтны хүсэлтийг харгалзан шаардлагатай үед цалинтай болон цалингүй чөлөө олгож ажлын цагийн зохицуулалт хийнэ.

6.3 Ажиллагсдын ажлын байрны баталгааг хангах, хүний нөөцийн төлөвлөлт зохион байгуулалтыг сайжруулах үүднээс ирээдүйд шаардлагагүй болох,

Н.Монхтүвшин

5



нэмэгдэл ур чадвар шаардагдах, цомхотголд орж болзошгүй ажлын байрны судалгаа гаргаж, урьдчилан хүний нөөцөө сургах, өөр ажилд шилжүүлэх давтан сургах арга хэмжээ авна.

Долоо. Нийгмийн хамгааллын асуудлын талаар

7.1 Ажилтнуудад хоол, унааны нэмэгдлийг хоног тутамд бодож олгох ба хэмжээг тухайн үеийн үнэ ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан Хамтын гэрээ, дотоод хэм хэмжээнд заасны дагуу нэмэгдүүлнэ.

7.2. Ажиллагсдын орон сууц шинээр худалдан авах, нөхцөл сайжруулах, хөнгөлөлттэй зээл, цалингийн урьдчилгаа авах, гэр, хашаа, хувийн орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх арга хэмжээг ажил олгогчоос санхүүгийн чадавхтай уялдуулан үйл ажиллагааны зардалд төсөвлөн суулгаж Хамтын гэрээнд заасан хувь хэмжээгээр тогтоож шийдвэрлэнэ.

7.3. Ажилтны төрсөн эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхэд нас барсан тохиолдолд мөнгөн тусламж үзүүлнэ.

7.4. Ажилтан ердийн галлагаатай орон сууц, гэрт амьдардаг бол ажил олгогчоос жилдээ нэг удаа түлээ, түлшний хөнгөлөлт үзүүлнэ.

7.5. Байгалийн гамшиг болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас ажилтан, түүний байнга оршин суудаг гэр, сууцанд аюул, хохирол учирсан тохиолдолд мөнгөн тусламж үзүүлнэ.

7.6. Салбарын хэмжээнд мөрдөх хүүхэд хамгааллын бодлогыг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, Эцэг эхийн зөвлөлүүдтэй хамтран хэрэгжүүлнэ.

Найм. Үйлдвэрчний эвлэлийн эрхийг хангах талаар

8.1. Үйлдвэрчний эвлэлийн эрхийн тухай хуульд заасан эрх, баталгааг хангахын зэрэгцээ ажил олгогч нь:

8.1.1 Аж ахуй нэгж, байгууллагууд нь Хамтын гэрээ, хэлэлцээр хийхэд шаардлагатай мэдээллийг Үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудад тухай бүр өгнө.

8.1.2 Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татварыг бэлэн бусаар хурааж, тухайн сард багтаан Үйлдвэрчний эвлэлийн хороодын дансанд ажил олгогч шилжүүлнэ.


8.1.3 Ажил олгогч нь Үйлдвэрчний эвлэлийн хороодыг ажиллах нөхцөл бололцоогоор /өрөө, хурал, уулзалт хийх байр, шаардлагатай судалгаа, холбогдох шийдвэр, журам/ хангана.

8.1.4 Иргэний нисэхийн салбарын чиглэлээр зохиогдох семинар, сургалт, хурал зөвлөгөөнд иргэний нисэхийн байгууллагуудын Үйлдвэрчний эвлэлийн идэвхтэн, сонгуультнуудыг оролцуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

8.2. Үйлдвэрчний эвлэлийн ажлыг хэвлэл, мэдээллээр сурталчлах, хамтарсан үзлэг, сургалт, шалгалт хийх, "Хөдөлмөрийн тухай", "Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль" болон хөдөлмөрийн харилцаатай холбогдох бусад хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх, гишүүдийг Үйлдвэрчний эвлэлийн сургалтад хамруулахад салбарын холбооны албан тоотыг үндэслэн цалинтай чөлөө олгоно

У. Мөнхбаяр

6



8.3. Үйлдвэрчний эвлэлийн байгууллага нь иргэний нисэхийн салбарын ажил, үйлчилгээний үнэ тарифыг зохих хэмжээгээр нэмэгдүүлэх, үйл ажиллагаа хэвийн явуулахад нь ажил олгогчид зохих дэмжлэг үзүүлнэ.

Ес. Нийгмийн түншлэлийн хүрээнд хамтран хэрэгжүүлэх ажлын талаар

9.1. Төрийн захиргааны төв байгууллага нь Иргэний нисэхийн салбарын чуулганыг 2 жилд нэг удаа зохион байгуулна.

9.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

9.3. Хүн амыг хамарсан халдварт өвчлөл гарсан тохиолдолд ажилтнуудын эрүүл мэнд, амь насыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг авч ажиллана.

9.4. Салбарын ажилтнуудыг орон сууцаар хангах зорилгоор орон сууц барих, хөнгөлөлттэй зээлд хамруулах хөтөлбөр гарган хэрэгжүүлж, төрийн захиргааны төв байгууллага, үйлдвэрчний эвлэлийн байгууллага, ажил олгогчийн зүгээс ажилтнуудад дэмжлэг үзүүлж, "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-тай хамтран ажиллана.

9.5. Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын шугамаар олон улсын ижил төстэй байгууллагад туршлага судлах, ажилтан солилцооны хөтөлбөрт хамрагдах тохиолдолд ажилтанд 6 сар хүртэлх хугацааны цалингүй чөлөө олгож болно.

Арав. Хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хяналт тавих талаар

10.1. Хамтын хэлэлцээрт орсон асуудлыг хугацаанд нь биелүүлж, хэрэгжүүлэх үүргийг ажил олгогч, хянах үүргийг төрийн захиргааны байгууллага хариуцна.

10.2. Салбарын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо нь салбарын нийт ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалагчийн хувьд хамтын хэлэлцээрт туссан асуудал бүрийг хугацаанд нь биелүүлэхийг шаардах, хэрэгжилтийн явц байдлыг төрийн захиргааны төв байгууллага, ажил олгогчийн төлөөлөлд мэдээлнэ.

10.3. Хамтын хэлэлцээр байгуулах явцад болон хэлэлцээрт тусгагдсан асуудлыг биелүүлээгүй үед хөдөлмөрийн хамтын маргаан үүсгэх эрхийг талууд тэгш эдэлнэ.

ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ




Ч.Мөнхтуяа

Зам, тээврийн яамны Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газрын дарга

Ч.Мөнхтуяа

БМЛ 7



Г.Алтангэрэл

Зам, тээврийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын нэгдсэн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн;

Я.Ганцэцэг

Зам, тээврийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн;

Б.Байгалмаа

Зам, тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн;

Э.Уянга

Зам, тээврийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын Салбарын хүний нөөцийн бодлого, агаар орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн;

У.Мөнхцэцэг

Зам, тээврийн яамны Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газрын ахлах зохион байгуулагч;

АЖИЛ ОЛГОГЧДЫГ ТӨЛӨӨЛЖ:

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, "ИНҮТ" ТӨХХК, "МИАТ" ТӨХХК

Э.Төрбаяр

Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга;

З.Туяа

Иргэний нисэхийн ерөнхий газрын Захиргаа удирдлага, хууль эрх зүйн газрын дарга;

Б.Отгонсүх

"ИНҮТ" ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал;

Д.Рэнцэнбямба

"ИНҮТ" ТӨХХК-ийн Захиргаа удирдлагын газрын дарга;

Б.Мөнхтамир

"МИАТ" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал;

Б.Дөлгөөн

"МИАТ" ТӨХК-ийн Хүний нөөцийн хэлтсийн дарга;

АЖИЛТНЫГ ТӨЛӨӨЛЖ:

МОНГОЛЫН ТЭЭВЭР, ХОЛБОО, ГАЗРЫН ТОСНЫ АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДИЙН ХОЛБОО

М.Болдсайхан

Монголын тээвэр, холбоо, газрын тосны ажилтны үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дарга;

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тусламтын хөндөгчдийг бүртгээ



Б.Энх-Амгалан ИНЕГ-ын ажиллагсдын үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга;

Х.Гансүх "ИНУТ" ТӨХХК-ийн Шалгалтын нислэг, зураглалын албаны ажилтны үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга

Д.Батбаатар "МИАТ" ТӨХК-ийн дэргэдэх үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга;

М.Саранцацрал МҮЭХ-ны Хүний эрх, хуулийн газрын дарга;

Н.Батчимэг Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын ажилтны үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга.

--oOo--

У. Мөнхтүвшин

Бон 9

